



СОЁМБОМ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

МЭДЭЭ

№225 /434/

2022.12.13

Цаг үе, үйл явдал

“БИДНИЙ БАХАРХАЛ” ТӨСЛИЙГ ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМАНД...



Монгол Улсын Ерөнхийлөгчийн үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газраас баталсан “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан иргэд, хүүхэд, залуучуудад эх оронч үзлийг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх “Бидний бахархал” төслийн нээлт Хэнтий аймгийн Дэлгэрхаан суманд амжилттай зохион байгуулагдлаа.

Уг арга хэмжээг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Монгол цэргийн нэгдсэн холбоо, Хэнтий аймгийн ЗДТГ-ы Цэргийн

штаб хамтран зохион байгуулсан юм. “Бидний бахархал” төслийн арга хэмжээнд Дэлгэрхаан сумын ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, Зэвсэгт хүчний 232 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагчид оролцлоо.

Энэ үеэр Монгол Улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, МЦНХ-ны Удирдах зөвлөлийн гишүүн, доктор профессор хошууч генерал Н.Жалбажав “Тусгаар тогтнол-улс үндэсний үнэт зүйлсийн охь дээжис”, Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн, МЦНХ-ны Удирдах зөвлөлийн гишүүн, доктор Ж.Цогтсугар “Эх оронч үзэл, Монгол эх орон, монгол хүний бахархал” сэдвээр

тус тус сонирхолтой лекцийг бие бүрэлдэхүүнд сонордууллаа.

Үүний дараагаар “Мөнхөд дурсагдах баатрууд” ТББ-ын тэргүүн, доктор профессор, хурандаа Ж.Өвгөнбүргэд, Монгол цэргийн музейн ерөнхий менежер Б.Азбаяр нар МЦМ-н үзмэрүүдийг сурагчид, цэрэг дайчдад тайлбарлан танилцууллаа.

Дэлгэрхаан сумын сургуулийн сурагчид болон 232 дугаар ангийн дайчид хамтран хүрэлцэн ирсэн зочид төлөөлөгчдөд ая дууны мэндчилгээ дэвшүүллээ.

“ЗӨВ ХАНДЛАГА-ЭРХЭМ АНДУУД” НҮТТБ ГИШҮҮН БАЙГУУЛЛАГААР ЭЛСЛЭЭ



“Зөв хандлага-эрхэм андууд” НҮТТБ МЦНХ-нд элссэн анхдагч байгууллага болж, залуу үед зөв хандлагыг түгээн дэлгэрүүлэх, эх түүхээрээ бахархах, эх оронч үзэл, хүмүүжил, төлөвшил олгох, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагаас тэтгэвэр, чөлөөнд гарсан ахмадуудтай явган аялал, спортын арга хэмжээ зохион байгуулах зэрэг үйл ажиллагаагаар хамтран ажиллахаар боллоо.

Монгол цэргийн нэгдсэн холбоо



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-21	-32

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
38	25

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3.448	3.452
EUR	3.646	3.665
CNY	492	494
RUB	52.10	52.50
JPY	25.20	25.50
KRW	2.63	2.66

ЗУРХАЙ

2022.12.13 / МЯГМАР ГАРАГ /
БИЛГИЙН ТООЛЛЫН 20

ӨВЛИЙН ТЭРГҮҮН ЦАГААГЧИН
ГАХАЙ САР
ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ
ЦАГААН ХУЛГАНА ӨДӨР

Үс засуулбал:
Өлсөж ундаасна
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
08.33-16.59
БАРИЛДЛАГА:
Үхэх
ШҮТЭН БАРИЛДЛАГА:
Сэрэхүй

Тухайн өдөр могой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Эл өдөр амь таслах, хор найруулах үйлнээ зэрэгчлэн бүтнэ, амраг лугаа золгох, авшиг авах, ус гатлах, угаах зэрэгт сайн. Баруун нүд татвал садан ирэх, зүүн нүд татвал баярлах, баруун чих хангинавал гутамшиг болох, зүүн хангинавал завхарсныг сонсож цочих, бие татвал өмнө зүгээс зочин ирэх, хөл татвал хэрүүл гомдол болно.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 654,209,942

Эдгэрсэн

Нийт: 629,642,990

Нас барсан

Нийт: 6,660,238

Цаг үе, үйл явдал

ДЭД ХУРАНДАА А.БАТСҮХ ШИЛДЭГ ОРОЛЦОГЧООР ШАЛГАРЧЭЭ

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ энэ сарын 21-ний өдөр төрийн албан хаагчидтай уулзаж, Засгийн газраас хэрэгжүүлж буй “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хэрэгжилт, өнөөгийн байдал, тулгарч байгаа сорилт, төрийн албан хаагчдын үүрэг оролцоо, цаашид анхаарах асуудлын талаар санал бодлоо солилцсон юм. Тус уулзалтад яам, агентлаг, төрийн өмчит үйлдвэрийн газруудын төлөөлөл болох 1200 гаруй ажилтан, албан хаагч оролцлоо.

Энэхүү уулзалтаар “Алсын хараа-2050”, түүний хэрэгжилтийн эхний үе шат болох “Шинэ сэргэлтийн бодлого” сэдэвт богино хугацааны сургалтыг төрийн захиргааны төв байгууллагуудын түвшинд




зохион байгуулсан юм. Уг сургалтад 1426 төрийн алба хаагч хамрагдсан бөгөөд сургалтын төгсгөлд хамгийн идэвхтэй хамрагдсан 10 оролцогчийг шалгарууллаа.

Энэхүү шалгаруулалтын дүнгээр ЗХЖШ-ын Сургалт бэлтгэлийн газрын мэргэжилтэн дэд хурандаа А.Батсүх шилдгээр шалгарч Бүгд Найрамдах Солонгос Улсад зохион байгуулагдах “Урт хугацааны хөгжлийн бодлого: Төрийн албан хаагчийн оролцоо” сэдэвт сургалтад хамрагдах батламжийг Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнээс гардан авсан нь бидний бахархал билээ.

Хурандаа Б.ОТГОНБАЯР

ФОТО СУРВАЛЖИЛГА

ЦЭРГИЙН ДУУ БҮЖГИЙН 90 ЖИЛИЙН ОЙН БАЯРЫН ГЭРЭЛ ЗУРГУУДААС...



Сургалт

МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ №36

БА ҮСЭГ БҮХИЙ УНШИХ, БИЧИХ ДАДЛАГА
Өмнөх хичээлээр үзсэн БА гийгүүлэгч бүхий, уншихад хялбар, нэг юм уу хоёрхон үеэс бүтсэн, бичлэг дуудлага нь өнөөгийнхтэй бараг таардаг хялбар жишээ үгсийг унших, бичих дасгал дадлага хийцгээе. Зөв уншаад, хичээнгүйлэн бичиж кириллээр хөрвүүлээрэй.

Дармал, бичмэл тигээр:

